"ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨХХК

# НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

ЗӨВШӨӨРСӨН:

ИНЕГ-ЫН АГААРЫН НАВИГАЦИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД ИРГЭНИЙ НИСЭХИЙН ХЯНАЛТЫН АХЛАХ БАЙЦААГЧ П.ГАНБААТАР

2026 оны 3 -р сарын 31-ны өдөр

БАТЛАВ:

"ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.ЭНХЗОРИГ

2026 оны 3-р сарын 11-ны өдөр

ХЯНАСАН:

"ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨХХК-ИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА П.ГАНТӨГС

2026 оны 03-р сарын 11-ны өдөр

БОЛОВСРУУЛСАН:

"ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨХХК-ИЙН АГААРЫН НАВИГАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Д.БАЯРТОГТОХ

2026 оны 03-р сарын 10-ны өдөр

## ГАРЧИГ

Баталгаажуулалтын хуудас


| | | |
|---|---|---|
| Гарчиг | | i-1 |
| Түгээлтийн хуудас | | i-3 |
| Өөрчлөлтийн бүртгэл | | i-4 |
| **1.** | **Нэр томьёо болон товчлол** | 2 |
| **2.** | **ИНҮТ ТӨХХК-ИЙН НУТА-ны бүтэц, үйл ажиллагаа** | 3 |
| 2.1. | Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны алсын хараа, зорилго, үнэт зүйлс, уриа | 3 |
| 2.2. | Удирдах ажилтнуудын үүрэг хариуцлага | 4 |
| 2.3. | Зохион байгуулалтын бүтэц | 8 |
| **3.** | **НУТА-ны байршил, нэр, хаяг, эрхлэх үйлчилгээ, үйл ажиллагааны чиглэл цагийн хуваарь** | 9 |
| 3.1. | Хаяг | 9 |
| 3.2. | Албаны эрхлэх үйлчилгээ, үйл ажиллагааны чиглэл, зохицуулалт | 9 |
| 3.3. | Ажлын цагийн зохицуулалт, хязгаарлалт | 10 |
| 3.4. | Ажилтныг шилжүүлэн ажиллуулах | 11 |
| **4.** | **Сургалт, дадлага** | 12 |
| 4.2. | Сургалт дадлагад хамруулах | 12 |
| 4.3. | Сургалт дадлагын ангилал | 12 |
| 4.4. | Нислэгийн төлөвлөлтийн ажилтныг дадлагажуулах | 13 |
| **5.** | **Ажлын байранд нэвтрэх үеийн зохицуулалт** | 13 |
| 5.2. | Зөвшөөрөл | 13 |
| 5.3. | ШТХ-ийн ажлын байранд нэвтрэх үеийн зохицуулалт | 14 |
| **6.** | **Аюулгүй байдлын мэдээлэл түгээх** | 15 |
| **7.** | **Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд ажиллах хүний нөөцийн нөөц төлөвлөгөө** | 17 |
| 7.1. | Хүний нөөцийн нөөц төлөвлөгөө | 17 |
| 7.2. | Нөөц ажлын байр | 18 |
| **8.** | **Зааварт өөрчлөлт оруулах** | 18 |
| **9.** | **Хэсгүүдийн үйл ажиллагаа** | 19 |
| 9.1. | Нислэгийн цагийн хуваарь, зөвшөөрлийн хэсэг | 19 |
| 9.1.2. | НЦХЗХ-ийн бүтэц | 20 |
| 9.1.3. | Нислэгийн урсгал төлөвлөлтийн мэргэжилтний гүйцэтгэх чиг үүрэг | 20 |
| 9.1.4. | Нислэгийн урсгалын судалгааны мэргэжилтний гүйцэтгэх чиг үүрэг | 27 |
| 9.1.5. | Нислэгийн цагийн хуваарийн мэргэжилтний гүйцэтгэх чиг үүрэг | 27 |
| 9.1.6. | Агаарын зайн мэргэжилтний гүйцэтгэх чиг үүрэг | 28 |
| 9.1.7. | Тоног төхөөрөмж, мэдээллийн сүлжээ | 29 |
| 9.1.8. | Баримт бичгийн хадгалалт | 29 |
| 9.1.9. | Хавсралтууд | 30 |




ИНҮТ-АБЧҮГ №02
ХЯНАЛТТАЙ

| | | |
|---|---|---|
| 9.2. | Шуурхай төлөвлөлтийн хэсэг | 44 |
| 9.2.1. | Шуурхай төлөвлөлтийн хэсгийн үндсэн чиг үүрэг | 44 |
| 9.2.2. | Шуурхай төлөвлөлтийн хэсгийн бүтэц | 45 |
| 9.2.3. | Ахлах мэргэжилтний чиг үүрэг | 45 |
| 9.2.4. | Автоматжуулалт, сүлжээний мэргэжилтний гүйцэтгэх чиг үүрэг | 47 |
| 9.2.5. | Нислэгийн төлөвлөлтийн мэргэжилтний гүйцэтгэх чиг үүрэг | 48 |
| 9.2.6. | Нислэгийн бүртгэл, гүйцэтгэлийн операторын гүйцэтгэх чиг үүрэг | 51 |
| 9.3. | Ээлжийн зохион байгуулалт | 51 |
| 9.4. | Ээлж хүлээн авах | 52 |
| 9.5. | Ээлж хүлээлгэн өгөх | 52 |
| 9.6. | Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн өдөр тутмын төлөвлөгөө (ATFM-ADP) солилцох | 53 |
| 9.7. | Тоног төхөөрөмж, мэдээллийн сүлжээ | 54 |
| 9.8. | Баримт бичгийн хадгалалт | 55 |
| 9.9. | Хавсралтууд | 55 |
| **10.** | **Хэсгүүдийн харилцан ажиллагаа** | 70 |
| 10.1. | Нислэгийн цагийн хуваарь, зөвшөөрлийн хэсэг | 70 |
| 10.2. | Шуурхай төлөвлөлтийн хэсэг | 70 |
| **11.** | **Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэх** | 71 |
| 11.3. | Багтаамж хэтэрсэн үед | 72 |
| 11.4. | Урт хугцааны төлөвлөлтийн үе шат | 72 |
| 11.5. | Урьдчилсан төлөвлөлтийн үе шат | 72 |
| 11.6. | Шуурхай төлөвлөлтийн үе шат | 73 |
| 11.7. | Үйл ажиллагааны дараах дүн шинжилгээ | 73 |
| 11.8. | Агаарын зайн болон нисэх буудлын багтаамж | 74 |
| 11.9 | Хамтын шийдвэр гаргалт | 76 |
| 11.8.2 | Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн нэгж | 76 |
| 11.10. | Ахлах мэргэжилтний ажлын байрны чиг үүрэг | 78 |
| 11.11. | Төлөвлөлтийн мэргэжилтний ажлын байрны чиг үүрэг | 78 |
| 11.12. | Мэргэжилтний ажлын байрны чиг үүрэг | 78 |
| 11.13. | Операторын ажлын байрны чиг үүрэг | 79 |




ИНУТ-АБЧУГ №02
ХЯНАЛТТАЙ

## ТҮГЭЭЛТИЙН ХУУДАС

| № | Хаана | Хувь |
|---|---|---|
| 1 | ИНЕГ-ын АНАСГ-ын АНХХ | Үндсэн хувь |
| 2 | “ИНҮТ” ТӨХХК-ийн АБЧУГ | Үндсэн хувь |
| 3 | “ИНҮТ” ТӨХХК-ийн АНҮГ | Үндсэн хувь |
| 4 | НУТА-ны дарга | Хүчинтэй хувь |
| 5 | НЦХЗ-ийн хэсэг | Хүчинтэй хувь |
| 6 | ШТ-ийн хэсэг | Хүчинтэй хувь |



ИНҮТ-АБЧУГ №02
ХЯНАЛТТАЙ

## ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

| № | Боловсруулсан огноо | Өөрчлөлтийн товч утга | Хүчин төгөлдөр болсон огноо | Өөрчлөлт оруулсан ажилтан |
|---|---|---|---|---|
| 1-р хэвлэл 2026 | 2026.02.13 | “Иргэний нисэхийн үндэсний төв” Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулагдаж, компанийн дүрэм, бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталсантай холбогдуулан боловсруулсан анхны хэвлэл | 2026.02.26 | АНҮГ-ын дарга Д.Баяртогтох |
| 2-р хэвлэл 2026 | 2026.03.10 | “Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай “Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвлөлийн 2026 оны 02 дүгээр сарын 03-ны өдрийн 06/26 дугаартай тогтоол болон “Иргэний нисэхийн үндэсний төв” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчийг томилох тухай 2026 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 13/26 дугаартай тогтоолыг үндэслэн өөрчлөлт оруулан шинэчлэн боловсруулав. | | АНҮГ-ын дарга Д.Баяртогтох |



ИНҮТ-АБЧҮГ №02
ХЯНАЛТТАЙ

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НЭР ТОМЬЁО БОЛОН ТОВЧЛОЛ

## 1.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1.1. Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Иргэний нисэхийн тухай хууль, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай Монгол Улсын хууль, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүйн баримт бичгүүд, олон улсын гэрээ, ОУИНБ-ын стандарт, шаардлагууд, Иргэний нисэхийн дүрмүүд, ИНД-172.85 заалт болон ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын баталсан тушаал, шийдвэр журам, зааврыг мөрдлөг болгон ажиллана.

## 1.2. НЭР ТОМЬЁО БОЛОН ТОВЧЛОЛ

"ИНҮТ" ТӨХХК - "Иргэний Нисэхийн Үндэсний Төв" төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компани

| | |
|---|---|
| **НУТА** | Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба |
| **ИНД** | Иргэний Нисэхийн дүрэм |
| **НХҮ** | Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ |
| **ИНЕГ** | Иргэний Нисэхийн Ерөнхий газар |
| **АБЧУГ** | Аюулгүй Байдал Чанарын Удирдлагын газар |
| **ХАБЭА** | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй |
| **ICAO** | International Civil Aviation Organization |
| **НХТЗОЖ** | Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам |
| **ОУИНБ** | Олон улсын иргэний нисэхийн байгууллага |
| **ШТХ** | Шуурхай төлөвлөлтийн хэсэг |
| **НЦХЗХ** | Нислэгийн цагийн хуваарь, зөвшөөрлийн хэсэг |
| **АБЧНУТ** | Аюулгүй Байдал Чанарын Нэгдсэн Удирдлагын Тогтолцоо |
| **АНҮАБЧНУТЗ** | Агаарын Навигацийн Үйлчилгээний Аюулгүй Байдал, Чанарын Нэгдсэн Удирдлагын Тогтолцооны Заавар |
| **ШУХТ** | Шуурхай удирдлага, хяналтын төв |
| **ЭХАТАМЗТ** | Эрэн хайх, авран туслах ажиллагааны мэдээлэл зохицуулах төв |

ИНҮТ-АБЧҮГ №02
ХЯНАЛТТАЙ

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. “ИНҮТ” ТӨХХК-ИЙН НУТА-НЫ БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБАНЫ АЛСЫН ХАРАА, ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС, УРИА

**АЛСЫН ХАРАА**

БҮС НУТГИЙН ХҮРЭЭНД НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА БОЛОХ

**ЗОРИЛГО**

МОНГОЛ УЛСЫН АГААРЫН ЗАЙД НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ, НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УРСГАЛЫГ АЮУЛГҮЙ, ШУУРХАЙ, ҮР АШИГТАЙ ТӨЛӨВЛӨХ

**ҮНЭТ ЗҮЙЛС**

МЭДЛЭГ, БОЛОВСРОЛ, ХАРИУЦЛАГАТАЙ ХҮНИЙ НӨӨЦ

**УРИА**

ШУУРХАЙ, ҮР АШИГТАЙ, НИСЛЭГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.

ИНҮТ-АБЧУГ №02
ХЯНАЛТТАЙ

## 2.2 УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

### 2.2.1 ҮНДСЭН ҮҮРЭГ:

| № | Албан тушаал | Үндсэн үүрэг |
|---|---|---|
| 1 | НУТА-ны дарга | 1. "ИНҮТ" ТӨХХК-ийн бодлого шийдвэрийг албаны нэгжүүдийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангах, Монгол улсын агаарын зайд нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэх, Чикагогийн конвенц, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Монгол Улсын Иргэний нисэхийн тухай хууль болон Иргэний нисэхийн багц дүрмүүд,"Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам"-ын шаардлагууд хангагдан ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих удирдлага зохион байгуулалтаар хангана.<br>2. Томилогдсон ажилтныг, үйл ажиллагаа, ажлын ачааллыг харгалзан шилжүүлэн ажиллуулах, ажил үүргийг орлон ба хавсран гүйцэтгүүлэх, дотоод сургалтад хамруулах, чөлөө олгох, ажлын үр дүнг тооцох, хууль тогтоомжид нийцүүлэн өөрийн чиг үүргийн хүрээнд шийдвэр гаргах, дүрэм, журам, заавар, хөтөлбөр, төлөвлөгөө, хуваарь боловсруулж биелэлтийг хангуулах, ажлын хэсэг, комисс томилох.<br>3. Байгууллагын ажлын шаардлага хэрэгцээг үндэслэн тухайн ажлын байранд тавигдах шаардлагад нийцүүлэн ажилтныг сонгон шалгаруулалтаар ажилд томилох, өөрчлөх, чөлөөлөх санал гаргах.<br>4. Захиргааны үйл ажиллагааны хүрээнд дүрэм, журам, заавар, гэрээ, хүний нөөцийн бодлого, стратегийн хэрэгжилт, гүйцэтгэлийг хянах, удирдлага, зохицуулалтаар хангах.<br>5. Иргэний нисэхийн салбарын бодлого, үйл ажиллагаа, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд албаны нэгж хэсгүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт тавих, үйл ажиллагааг удирдлагаар хангах.<br>6. Ажлын байрны хүрээнд явуулах бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх. |
| 2 | НУТА-ны Нислэгийн цагийн хуваарь, зөвшөөрлийн хэсгийн дарга | 1. "Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх зөвшөөрөл олгох журам"-ын дагуу нислэгийн төлөвлөлтийн үйл ажиллагаанд хяналт тавина.<br>2. Дотоод, гадаадын агаарын тээвэрлэгчдээс ирүүлсэн нислэгийн хүсэлт, түүнд холбогдох баримт бичгийг хүлээн авч, НХТЗОЖ-ын дагуу нислэгийн зөвшөөрөл дугаарыг агаарын тээвэрлэгчдэд дамжуулан, нислэгийн хөдөлгөөний, урсгал төлөвлөлтийн менежментийн үе |

ИНҮТ-АБҮҮГ №02
ХЯНАЛТТАЙ

| | | |
|---|---|---|
| | | шатуудад төлөвлөн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах.<br>3. Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, шийдвэрийн хүрээнд хэсгийн ажилтнуудын ажлын цаг, үр дүн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх, эрх зүйн баримт бичгүүдийн мөрдөлт, хэрэгжүүлэлт, ажлын хариуцлагад хяналт тавина.<br>4. Хэсгийн ажлын шаардлага хэрэгцээг үндэслэн тухайн ажлын байранд тавигдах шаардлагад нийцүүлэн ажилтныг сонгон шалгаруулалтаар ажилд томилох, өөрчлөх, чөлөөлөх санал гаргана.<br>5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, өөрийн харьяалах ажлын байр болон үйлдвэрлэлийн орчинд тохирсон дүрэм, журмыг боловсруулна.<br>6. Хэсгийн үйл ажиллагааг зохион байгуулж, нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллана.<br>7. Хэсгийн үйл ажиллагаатай холбогдолтой эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулах саналыг хүргүүлнэ.<br>8. Ажлын нөхцөл сайжруулах, хэсгийн ажилтнуудын мэдлэг боловсрол, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, арга хэмжээний талаар санал гаргаж шийдвэрлүүлнэ.<br>9. Нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үе шатуудад хэсгийн мэргэжилтнүүдэд зааварчилгаа, зөвлөгөө өгч, ажлын байруудын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг ханган, албаны удирдлагад нислэгийн төлөвлөлтийн мэдээ, мэдээллийг тухай бүр танилцуулна.<br>10. "ИНҮТ" ТӨХХК-ийн "Хөдөлмөрийн дотоод журам", албаны ажлын байрны дадлагын хөтөлбөрийн дагуу шинээр ажилд орох, шилжин ажиллах, урт хугацааны чөлөөнөөс эргэн орсон ажилтныг ажлын байранд дадлагажуулах ажлыг зохион байгуулна.<br>11. Хэсгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан удирдлагаар батлуулан, хэрэгжилтийг хангаж, удирдлагад тайлагнана.<br>12. Нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үйл ажиллагаанд гарч буй дутагдал, нислэгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөх аливаа аюул, эрсдэлийн талаарх мэдээллийг мэдээлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч шийтгэлгүй мэдээллийн системийг хэрэгжүүлж ажиллана.<br>13. Аюулгүй ажиллагааг хэсгийн үйл ажиллагаанд хэвшүүлэх, удирдлагын зааварчилгаа, хяналтаар хангана.<br>14. "ИНҮТ" ТӨХХК-ийн үзлэг шалгалт, дүгнэлтийн дагуу хийгдэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, |

ИНҮТ-АБҮГ №02
ХЯНАЛТТАЙ

| | | |
|---|---|---|
| | | биелэлтийг тогтоосон хугацаанд нь хүргүүлэх арга хэмжээг авч ажиллана.<br>15. Удирдлагын шийдвэрийн дагуу ШТХ-ийн даргыг ээлжийн амралттай, томилолттой, өвчтэй, чөлөөтэй байх хугацаанд ажил үүргийг нь хавсран гүйцэтгэнэ.<br>16. Ажлын байрны хүрээнд явуулах бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх. |
| 3 | НУТА-ны Шуурхай төлөвлөлтийн хэсгийн дарга | 1. Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн урьдчилсан болон шуурхай төлөвлөлтийн үйл явцад хяналт тавьж ажиллана.<br>2. Агаарын зайн болон нисэх буудлын багтаамжид нийцүүлэн "Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам"-ын дагуу шуурхай төлөвлөлтийн үе шатанд ирүүлсэн нислэгийн хүсэлтэд нислэгийн зөвшөөрөл дугаарыг агаарын тээвэрлэгчдэд дамжуулан төлөвлөж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах<br>3. Ажлын болон ажлын бус цагаар нислэгийн гүйцэтгэлийг бүрдүүлэх хяналт тавих<br>4. Төлөвлөгдсөн нислэгийн өөрчлөлтийг баталгаажуулан холбогдох алба, салбар, нэгжүүдийг нислэгийн төлөвлөлтийн мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах.<br>5. Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, шийдвэрийн хүрээнд хэсгийн ажилтнуудын ажлын цаг, үр дүн, төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх, эрх зүйн баримт бичгүүдийн мөрдөлт, хэрэгжүүлэлт, ажлын хариуцлагад хяналт тавина.<br>6. Хэсгийн ажлын шаардлага хэрэгцээг үндэслэн тухайн ажлын байранд тавигдах шаардлагад нийцүүлэн ажилтныг сонгон шалгаруулалтаар ажилд томилох, өөрчлөх, чөлөөлөх санал гаргана.<br>7. Хэсгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллана.<br>8. Хэсгийн үйл ажиллагаатай холбогдолтой эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулах саналыг хүргүүлнэ.<br>9. Ажлын нөхцөл сайжруулах, хэсгийн ажилтнуудын мэдлэг боловсрол, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, арга хэмжээний талаар санал гаргаж шийдвэрлүүлнэ.<br>10. Хэсгийн ажилчдын ээлжийн хуваарь, өөрчлөлтийг албаны даргаар батлуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.<br>11. "ИНҮТ" ТӨХХК-ийн "Хөдөлмөрийн дотоод журам", албаны ажлын байрны дадлагын хөтөлбөрийн дагуу шинээр ажилд орох, шилжин ажиллах, урт хугацааны чөлөөнөөс эргэн орсон ажилтныг ажлын байранд дадлагажуулах ажлыг зохион байгуулна. |

ИНҮТ-АБЧҮГ ҮЙЛС
ХЯНАЛТТАЙ

| | | |
|---|---|---|
| | | 12. Хэсгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан удирдлагаар батлуулан, хэрэгжилтийг хангаж, удирдлагад тайлагнана.<br>13. Нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үйл ажиллагаанд гарч буй дутагдал, нислэгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөх аливаа аюул, эрсдэлийн талаарх мэдээллийг мэдээлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, шийтгэлгүй мэдээллийн системийг хэрэгжүүлж ажиллана.<br>14. Аюулгүй ажиллагааг хэсгийн үйл ажиллагаанд хэвшүүлэх, удирдлагын зааварчилгаа, хяналтаар хангана.<br>15. "ИНҮТ" ТӨХХК-ийн үзлэг шалгалт, дүгнэлтийн дагуу хийгдэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, биелэлтийг тогтоосон хугацаанд нь хүргүүлэх арга хэмжээг авч ажиллана.<br>16. Удирдлагын шийдвэрийн дагуу НЦХЗХ-ийн даргыг ээлжийн амралттай, томилолттой, өвчтэй, чөлөөтэй байх хугацаанд ажил үүргийг нь хавсран гүйцэтгэнэ.<br>17. Ажлын байрны хүрээнд явуулах бусад уйл ажиллагааг хэрэгжүүлэх. |

ИНҮТ-АБҮГ №02
ХЯНАЛТТАЙ

## 2.3 ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

### 2.3.1 “ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК-ИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ШУГАМАН ХАМААРЛЫН ЗУРАГЛАЛ:




ХЯНАЛТТАЙ

2.3.2 "ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ " ТӨХХК-ИЙН НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБАНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ШУГАМАН ХАМААРЛЫН ЗУРАГЛАЛ:




## ГУРАВДУГААР БҮЛЭГ. НУТА-НЫ БАЙРШИЛ, НЭР, ХАЯГ, АЛБАНЫ ЭРХЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ ЦАГИЙН ХУВААРЬ

3.1 ХАЯГ

Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо, Буянт-Ухаа, Улаанбаатар хот, Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба.

3.2 АЛБАНЫ ЭРХЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ЗОХИЦУУЛАЛТ

3.2.1 Албаны үйл ажиллагааны үндсэн зорилт нь Монгол Улсын агаарын зайд Нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үйлчилгээг үзүүлэх, Монгол улсын нутаг дэвсгэрт үйлдэгдэх гадаад дотоодын агаарын тээвэрлэгчдийн нислэгийн хүсэлт, олон улсын өнгөрөлт, хөөрөлт буулт, орон нутгийн нислэгүүдийн холбогдох материалуудыг хүлээн авч, нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангах, нислэгийн гүйцэтгэлийн мэдээллийн санг тогтмол үүсгэхэд оршино.

3.2.2 Алба нь Монгол Улсын агаарын зайд аюулгүй, үр ашигтай нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэх, үндэсний эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх бодлогыг баримтлан ажиллах, нислэгийн гүйцэтгэл бүртгэх, тайлагнах үйлчилгээ үзүүлэх үндсэн зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:

а) Монгол Улсын болон гадаад улсын агаарын хөлгийн нислэгт, нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийн үе шатуудад нийцүүлэн төлөвлөх;

ХЯНАЛТТАЙ

б) Агаарын тээвэрлэгчдээс ирүүлсэн нислэгийн хүсэлтийг хүлээн авч нислэгийн зөвшөөрлийн дугаарыг агаарын тээвэрлэгчдэд дамжуулах;

в) Нислэгийн хөдөлгөөний урт, дунд хугацааны болон шуурхай төлөвлөлтийг гүйцэтгэж, түүнтэй холбогдох өөрчлөлт хийх;

г) Бүс нутгийн хэмжээнд нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийг менежментийг нэвтрүүлэх;

д) Нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлт, гүйцэтгэлийн мэдээ, судалгааг жил, улирал, сар, өдөр гэх мэт шаардлагатай хугацаагаар ангилан боловсруулж, мэдээллээр холбогдох байгууллага, салбар нэгжийг хангах.

3.2.3 Алба нь нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийг хэрэгжүүлэх чиг хандлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

| № | НУТА-ны нэгжийн нэр | Эрхлэх үйлчилгээ | Цагийн хуваарь |
|---|---|---|---|
| 1 | Нислэгийн цагийн хуваарь, зөвшөөрлийн хэсэг | Олон улс, орон нутгийн нислэгийн урт хугацааны, урьдчилсан, шуурхай төлөвлөлтийн үйлчилгээ, Нислэгийн төлөвлөлт, гүйцэтгэлийн мэдээ, судалгаа. | Даваа–Баасан гараг 07:00-08:30 цагийн хооронд эхэлж, 16:00-17.30 цагийн хооронд дуусна (8 цаг) |
| 2 | Шуурхай төлөвлөлтийн хэсэг | Олон улс, орон нутгийн нислэгийн урьдчилсан, шуурхай төлөвлөлтийн болон нислэгийн гүйцэтгэл бүртгэлийн үйлчилгээ, Албаны үйл ажиллагаанд ашиглагдаж буй системийн хөгжүүлэлт. | 24цаг |

3.2.4 Алба нь холбогдох хууль, журам, стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлог шинж чанарыг илэрхийлсэн бэлгэдэл, туг, лого, дүрэмт хувцастай байна.

3.3 АЖЛЫН ЦАГИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЯЗГААРЛАЛТ

3.3.1 Албаны үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан Шуурхай төлөвлөлтийн хэсгийг 24 цагийн турш тасралтгүй ээлжийн зохион байгуулалтаар ажиллуулах ба ээлжийн ажилтнуудын (нислэгийн төлөвлөлтийн мэргэжилтэн, нислэгийн бүртгэл, гүйцэтгэлийн оператор) ажил, үүргээ гүйцэтгэх хугацаа гэдэг нь ээлжийн өмнөх зааварчилгаа, ажлын байран дээр ажиллах хугацаа, завсарлага, ээлжийн дараах шүүмж ярианы нийлбэр нийт хугацаа байна.

3.3.2 Өдрийн ажилтнуудын ажлын цагийг "ИНҮТ" ТӨХХК-ийн "Хөдөлмөрийн дотоод журам"-д заасны дагуу мөрдөж ажиллана.

ИНҮТ-АБЧҮГ №02
ХЯНАЛТТАЙ

3.3.3 Ажлын шаардлагаар хамрагдаж буй нислэгийн төлөвлөлтийн анхан болон давтан сургалтын цагийг ажилласан цагт тооцно.

3.3.4 Нислэгийн төлөвлөлтийн ажилтны ажил, үүргээ гүйцэтгэх хугацаа нь хоногт 12 цагаас ихгүй байна.

3.3.5 Ээлж хоорондын тасралтгүй амралт нь 12 цагаас багагүй хугацаатай байна.

3.3.6 Орон нутгийн цагаар 22 цагаас 06 цаг хүртэлх хугацааг шөнийн цагт тооцно. Шөнийн цагаар ажиллах ээлжийг шөнийн ээлж гэнэ.

3.3.7 Ажилтан нь шөнийн ээлжид дараалан 2-оос илүү удаа ажиллахыг хориглоно.

3.3.8 Дараалан 2 удаа шөнийн ээлжид ажилласан ажилтны дараагийн ээлж хүртэлх тасралтгүй амралт нь 72 цагаас багагүй байна.

3.3.9 Нөхөн хангалтаар ажиллах гэдэг нь нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн тасралтгүй үйл ажиллагааг хангах үүднээс харьяалах албан тушаалтнаас урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн ажил, үүрэг гүйцэтгүүлэх хугацааг хэлнэ.

3.3.10 Нэгжийн удирдах ажилтны гаргаж буй ээлжийн хуваарь нь нэг маягттай байна.

3.4 АЖИЛТНЫГ ШИЛЖҮҮЛЭН АЖИЛЛУУЛАХ

3.4.1 Үйлдвэрлэлийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтныг ажлын байранд шилжүүлэн ажиллуулж болно.

3.4.2 Шилжүүлэн ажиллуулах ажилтныг харьяалсан нэгжийн удирдлага нь ажилтанд тавигдах шаардлагыг үндэслэн тодорхойлно.

3.4.3 Шилжүүлэн ажиллуулах ажилтныг харьяалсан нэгжийн удирдлагын тодорхойлолтод үндэслэн ажлын байранд дадлагажуулах шийдвэрийг албаны дарга гаргана.

3.4.4 Шилжин ажиллаж буй ажилтныг батлагдсан дадлагын хөтөлбөрийн дагуу ажлын байранд дадлагажуулна.

3.4.5 Ажилтан дадлагын хөтөлбөрт бүрэн хамрагдсаны дараа дадлагын тайланг албаны даргад тайлагнана.

3.4.6 Шилжин ажиллах ажилтныг харьяалсан нэгжийн даргын тодорхойлсон, дадлагын ажлын тайланд үндэслэн ажлын байранд томилон ажиллуулна.

3.4.7 Албаны зорилго зорилтыг ханган ажиллах мэргэжил, мэргэшил, ажлын туршлагатай, зөв хандлагатай ажилтнуудыг сонгон шалгаруулахад холбогдох нэгжүүдтэй хамтран ажиллана.

НУТ-АБЧУГ №02
ХЯНАЛТТАЙ

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СУРГАЛТ, ДАДЛАГА

1.1 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1.1 Энэхүү бүлгийн зорилго нь НУТА-д шинээр орсон ажилчдыг дадлагажуулах, ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг хадгалах давтан болон мэргэшүүлэх сургалттай холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2 СУРГАЛТ ДАДЛАГАД ХАМРУУЛАХ

1.2.1 НУТА нь ажилтнуудын сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж ОУИНБ-ын баримт бичгүүдэд тусгагдсан шаардлагын хүрээнд хөтөлбөр боловсруулан ИНД-141 дүрмийн дагуу гэрчилгээжсэн Нисэхийн сургалтын байгууллага эсхүл ИНЕГ-аас хүлээн зөвшөөрсөн сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулна.

1.2.2 Сургалтыг ИНД-141 дүрмийн дагуу гэрчилгээжсэн Нисэхийн сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулах тохиолдолд харилцан ажиллагааны журмаар зохицуулна.

1.2.3 Ажлын байранд дадлагажуулах болон шилжих сургалтын хөтөлбөрийг хариуцсан хэсгийн удирдлагууд боловсруулж НУТА-ны дарга батална.

1.3 СУРГАЛТ, ДАДЛАГЫН АНГИЛАЛ

1.3.1 Ажилтныг дараах сургалтуудад хамааруулна. Үүнд:

а) Анхан шатны сургалт;

i. Анхан шатны сургалтыг Чикагогийн конвенцын хэлэлцэн тохирогч аль нэг улс эсхүл ИНД-141 дүрмийн дагуу гэрчилгээжсэн Нисэхийн сургалтын байгууллагад байгууллагын хэрэгцээ шаардлагыг үндэслэн зохион байгуулна.

ii. Нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн ажилтан нь эрхлэх ажлын хүрээнд анхан шатны сургалтад бүрэн хамрагдсан байна.

б) Шилжих буюу хувьсах сургалт;

i. Нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн үйл ажиллагаа, зохион байгуулалтад өөрчлөлт орохтой холбогдол бүхий сургалт нь шилжих буюу хувьсах сургалт байна.

ii. Шилжих буюу хувьсах сургалтыг Нислэгийн төлөвлөлтийн үйл ажиллагаа, зохион байгуулалтад өөрчлөлт, шилжилт явагдах үед шаардлагатай тохиолдолд зохион байгуулна. Үүнд: Агаарын зайн зохион байгуулалт, нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үйл ажиллагааны өөрчлөлт, тоног төхөөрөмжийн өөрчлөлт, журам, заавар гэрээний өөрчлөлт г.м.

в) Нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн давтан сургалт;

i. Нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн давтан сургалт нь тусгайлсан зорилтот сургалт бөгөөд Нислэгийн төлөвлөлтийн ажилтны суурь

ИНУТ-АБЧУГ №03
ХЯНАЛТТАЙ

мэдлэг, туршлага, ур чадварыг хадгалах болон сэргээх сургалт байна. Давтан сургалтыг 2 жил тутам нэг удаа зохион байгуулна.

г) Хөгжүүлэх сургалт:

i. Хэсгийн дарга, мэргэжилтэн, операторуудын суурь мэдлэг, туршлага, ур чадварыг хөгжүүлж мэргэжил мэдлэгийг дээшлүүлж мэргэшүүлэх зорилгоор нислэг төлөвлөлтийн үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалттай холбоотой мэргэших буюу хөгжих сургалтыг явуулах. Үүнд: Нисэхийн англи хэлний сургалт, хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалт, аюулгүй ажиллагааны удирдлага, чанарын дотоод хяналт, хүний хүчин зүйл г.м.

## 1.4 НИСЛЭГИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН АЖИЛТНЫГ ДАДЛАГАЖУУЛАХ

1.4.1 Ажилтныг дараах тохиолдлуудад ажлын байранд дадлагажуулна. Үүнд:

а) Шинээр томилогдсон,
б) Ажлын байр шилжин ажиллах,
в) 3 сараас дээш хугацаагаар ажлаас чөлөөлөгдөн эргэн ажилд орох.
Ажлын байрны дадлага

1.4.2 Ажлын байрны дадлагад хамрагдах:

а) Ажлын байрны дадлагын хөтөлбөр, төлөвлөгөөг албаны дарга батална.
б) Дадлагыг батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу томилогдсон этгээдийн удирдлага дор гүйцэтгэнэ.

4.4.3 Ажлын байранд дадлагажигч нь албаны удирдлагуудад дадлагын тайланг тавина.

4.4.4 Дадлагажигч ажилтны тайлангийн танилцуулга нь электрон болон цаасан хэлбэрээр байх ба холбогдох материалыг хавсаргасан байна.

# ТАВДУГААР БҮЛЭГ.АЖЛЫН БАЙРАНД НЭВТРЭХ ҮЕИЙН ЗОХИЦУУЛАЛТ

## 5.1 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

5.1.1 Ээлжийн ажилтны ажлын байрны дэг журмыг сайжруулах, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа эрсдэлээс хамгаалахад оршино.

5.1.2 НУТА-ны Шуурхай төлөвлөлтийн хэсгийн ажлын байранд ажлын шаардлагаар нэвтрэх, зочид ирэх, танилцах, зураг авах, нэвтрүүлэг хийх зэрэг үеийн үйл ажиллагааг зохицуулна.

## 5.2 ЗӨВШӨӨРӨЛ

5.2.1 Зөвшөөрлийг НУТА-ны даргаас утсаар эсхүл албан бичгээр авна.

ХЯНАЛТТАЙ

5.2.2 Зөвшөөрөл нь дараах агуулгатай байна.Үүнд:

а) Ажлын байранд зочлох зорилго;
б) Бүрэлдэхүүн хүний тоо;
в) Огноо, цаг, хугацаа;
г) Үргэлжлэх хугацаа.

5.2.3 Зөвшөөрлийг үндэслэн холбогдох ажлын байранд нэвтрэх зочид төлөөлөгчдийн үйл ажиллагааг нэгжийн удирдлага зохион байгуулна.

5.3 ШТХ-ИЙН АЖЛЫН БАЙРАНД НЭВТРЭХ ҮЕИЙН ЗОХИЦУУЛАЛТ

5.3.1 Ажлын байранд нэвтрэх зочдод дараах зааварчилгааг өгнө. Үүнд:

а) Гар утсаа унтраах;
б) Тоног төхөөрөмжид хүрэхгүй байх;
в) Чанга ярих, дуу чимээ гаргахгүй байх;
г) Ажлын байранд зөвшөөрөлгүй зураг авахгүй байх;
д) Гадуур хувцастай орохыг хориглох;
ж) Нислэгийн төлөвлөлтийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох үйлдэл гаргахгүй байх;

5.3.2 Зочид төлөөлөгчдөд ажлын байрны үйл ажиллагааны талаарх танилцуулгыг тухайн нэгжийн удирдлага эсхүл тусгайлан хүн томилж хийлгэнэ.

5.3.3 Дараах тохиолдолд зочид төлөөлөгчдийг ажлын байранд нэвтрэх зөвшөөрлийг түр хугацаагаар хойшлуулж болно. Үүнд:

а) Тухайн ажлын байранд онцгой нөхцөл, тохиолдол үүссэн үед;
б) Ажлын ачаалалтай үед.

НУТ-АБҮГ №02
ХЯНАЛТТАЙ

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ

6.1 Нисэхийн осол , ноцтой зөрчил , үйл ажиллагаанд гарсан аюулгүй байдалд нөлөөлөх тохиолдлын талаарх мэдээллийг АНҮАБЧНУТЗ-ын ЖУ-2 журмын дагуу мэдээлнэ.

6.2 Нислэгийн төлөвлөлтийн үйл ажиллагаа болон нислэгийн, аюулгүй байдалтай холбогдолтой мэдээллийг цаг тухайд нь утас болон боломжит бусад сувгуудыг ашиглан доорх схемийн дагуу нэгжийн удирдлага болон албаны удирдлагад мэдээлнэ. Үүнд:

а) НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБАНЫ МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ СХЕМ




НУТ-АБЧУГ №02
ХЯНАЛТТАЙ

б) БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН БОЛОН ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖСЭН ҮЕД АЛБАНЫ МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ СХЕМ




6.3 Гамшгаас хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 10 дугаар зүйлд заасан зэрэглэлийн дагуу хариу арга хэмжээний төлөвлөгөө, заавар журмыг боловсруулан албаны даргаар батлуулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

6.4 Бүх нийтийн бэлэн байдлын болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд Монгол Улсын Засгийн газар Улсын онцгой комиссын тогтоол, шийдвэр, Зам тээврийн хөгжлийн сайдын тушаал, албан даалгавар,"ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын тушаал, албан даалгавар, журам, заавар болон албаны даргын баталсан холбогдох журам, зааврыг мөрдлөг болгон ажиллана.

6.5 Онцгой нөхцөл, байдал үүссэн үед энэхүү заавар болон "ИНҮТ" ТӨХХК -ийн харьяа алба салбар болон харилцагч байгууллагуудтай байгуулсан харилцан ажиллагааны зохицуулалтын журамд заасны дагуу мэдээллийг түргэн шуурхай солилцож ажиллана.

6.6 Нислэгийн төлөвлөлт, зөвшөөрлийн дугаар, гүйцэтгэлийн үйл ажиллагаатай холбогдолтой мэдээллийн нууцлалыг эрх бүхий байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу хүргүүлэхээс бусад тохиолдолд чандлан хадгална.

6.7 Нислэгийн төлөвлөлтийн үйл ажиллагаа болон нислэгийн, аюулгүй байдалтай холбогдолтой мэдээлэлд дараах зүйлсийг хамааруулан ойлгох ба "ИНҮТ" ТӨХХК-ийн АБЧНУТ-д заасны дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

ИНҮТ-АБЧНУГ №02
ХЯНАЛТТАЙ

а) Үйл ажиллагаанаас хамаарсан үл тохирол;
б) Нислэгийн үйл ажиллагаанаас хамаарсан үл тохирол;
в) Барилга, тоног, төхөөрөмжийн үйл ажиллагаанаас хамаарсан үл тохирол;
г) Онцгой нөхцөлийн үе /Байгалийн давагдашгүй хүчин зүйлс гал түймэр, үер усны гамшиг, газар хөдлөлт, эрчим хүчний доголдол, аюулт цар тахал, халдварт өвчин гэх мэт/.

## ДОЛООДУГААР БҮЛЭГ .ГАМШГААС ХАМГААЛАХ БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГ БОЛОН ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖСЭН ХУГАЦААНД АЖИЛЛАХ ХҮНИЙ НӨӨЦИЙН НӨӨЦ ТӨЛӨВЛӨГӨӨ

### 7.1 ХҮНИЙ НӨӨЦИЙН НӨӨЦ ТӨЛӨВЛӨГӨӨ

НУТА-ны ажилтнууд нь бүх нийтийн бэлэн байдлын зэрэг болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хүний нөөцийн хомсдол үүсэх тохиолдолд ажлын 8 цаг болон ээлжийн зохион байгуулалттайгаар (Хүснэгт 1)-т үзүүлсэн нөөц төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулна.

*Тайлбар: Үүссэн нөхцөл байдалтай хамааралтайгаар "ИНУТ" ТӨХХК-ийн Захиргаа удирдлагын газартай хамтарч доорх хуваарьт өөрчлөлт оруулж болно.*

Хүснэгт 1

| № | Албан тушаал | Орон тоо | Ажлын цаг | Орлох албан тушаалтан | Орлох орон тоо |
|---|---|---|---|---|---|
| 1 | Нислэгийн цагийн хуваарь, зөвшөөрлийн хэсгийн дарга | 1 | 8 цаг | Шуурхай төлөвлөлтийн хэсгийн дарга | 1 |
| 2 | Шуурхай төлөвлөлтийн хэсгийн дарга | 1 | 8 цаг | Нислэгийн цагийн хуваарь, зөвшөөрлийн хэсгийн дарга | 1 |
| 3 | Шуурхай төлөвлөлтийн хэсгийн ахлах мэргэжилтэн | 1 | 8 цаг | Нислэгийн урсгал төлөвлөлтийн мэргэжилтэн | 1 |
| 4 | Нислэгийн урсгал төлөвлөлтийн мэргэжилтэн | 6 | 8 цаг | Нислэгийн урсгал төлөвлөлтийн мэргэжилтэн | 1 |
| | | | | Нислэгийн төлөвлөлтийн мэргэжилтэн | 1 |
| 5 | Нислэгийн судалгааны мэргэжилтэн | 2 | 8 цаг | Нислэгийн судалгааны мэргэжилтэн | 1 |
| 6 | Нислэгийн цагийн хуваарийн мэргэжилтэн | 2 | 8 цаг | Нислэгийн цагийн хуваарийн мэргэжилтэн | 1 |
| 7 | Агаарын зайн мэргэжилтэн | 2 | 8 цаг | Агаарын зайн мэргэжилтэн | 1 |
| 8 | Автоматжуулалт, сүлжээний мэргэжилтэн | 1 | 8 цаг | - | |
| 9 | Нислэгийн төлөвлөлтийн мэргэжилтэн | 2 | 8 цаг | Нислэгийн төлөвлөлтийн мэргэжилтэн | 1 |

ИНУТ-АБЧГ №02
ХЯНАЛТГАЙ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Нислэгийн урсгал төлөвлөлтийн мэргэжилтэн | 1 |
| 10 | Нислэгийн төлөвлөлтийн мэргэжилтэн | 5 | 24 цаг/5,4, 3 ээлж | Нислэгийн төлөвлөлтийн мэргэжилтэн/ өдөр | 1 |
| | | | | Нислэгийн урсгал төлөвлөлтийн мэргэжилтэн | 1 |
| 11 | Нислэгийн бүртгэл, гүйцэтгэлийн оператор | 6 | 24 цаг/5,4, 3 ээлж | Нислэгийн бүртгэл, гүйцэтгэлийн оператор | 1 |

7.2 НӨӨЦ АЖЛЫН БАЙР

7.2.1 Алба нь хүний нөөцийг хөгжүүлэх, нөөцийг үр ашигтай ашиглах зорилгоор нөөц ажлын байрыг зөв зохион байгуулж ажиллана. Үүнд: Албаны төв байр /НЦХЗХ/, ШТХ-ийн ажлын байр, тоног төхөөрөмж нь харилцан нөөц ажлын байр болно.

## НАЙМДУГААР БҮЛЭГ. ЗАААВРТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

8.1 НУТА нь зааврын хүчин төгөлдөр хувийг ажлын байранд байнга хадгална.

8.2 НУТА нь зааварт дараах тохиолдолд өөрчлөлт оруулах саналыг Агаарын навигацийн үйлчилгээ хариуцсан нэгжид хүргүүлнэ.
Үүнд:

а) НУТА-ны бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орох;
б) НУТА-ны удирдах албан тушаалтны бүрэлдэхүүнд өөрчлөлт орох;
в) Байгууллагын хаяг, телефон утас, факсын дугаар зэрэг харилцах хаягт өөрчлөлт орох;
г) Эрхлэх үйлчилгээний жагсаалтад өөрчлөлт орох;
д) Нислэгийн төлөвлөлтийн үйл ажиллагаа нь хөрш зэргэлдээ улсын нислэгийн төлөвлөлтөд нөлөөлөхүйц өөрчлөлт орох г.м.

8.3 Агаарын навигацийн үйлчилгээ хариуцсан нэгж нь баримт бичигт оруулах өөрчлөлтийн саналыг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдөр болон 8 дугаар сарын 15-ны өдөр тус тус хүлээн авах бөгөөд ирсэн тушаал шийдвэр, саналын дагуу баримт бичиг боловсруулах, өөрчлөлт оруулах үйл явцыг эхлүүлнэ. Шаардлагатай бол ажлын 3-5 өдөрт багтаан эхний хэлэлцүүлгийг явуулна. Шинээр боловсруулж буй баримт бичгийн бүтэц, агуулгыг хэлэлцүүлгийн үеэр тодорхойлно. Баримт бичигт зайшгүй орох шаардлагатай, үйл ажиллагаанд шууд нөлөөлөхүйц өөрчлөлтийн саналыг тухай бүрд нь хүлээн авч шийдвэрлэнэ.

ИНЖ-АБЧИГ №02
ХЯНАЛТТАЙ

# ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ХЭСГҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 9.1 НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ, ЗӨВШӨӨРЛИЙН ХЭСЭГ

9.1.1 Нислэгийн цагийн хуваарь, зөвшөөрлийн хэсгийн үндсэн үүрэг:

9.1.1.1 НЦХЗХ нь дотоод, гадаадын агаарын тээвэрлэгчдээс ирүүлсэн нислэгийн хүсэлт, түүнд холбогдох баримт бичгийг хүлээн авч, НХТЗОЖ-ын дагуу нислэгийн зөвшөөрлийн дугаарыг агаарын тээвэрлэгчдэд дамжуулна, нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үе шатуудад төлөвлөнө.

9.1.1.1 Монгол улсын агаарын зайд үйлдэгдэх олон улс, орон нутгийн хуваарьт болон хуваарьт бус нислэгийн урсгалыг нэмэгдүүлэхэд чиглэн нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежмент, хамтын шийдвэр гаргалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дотоод, гадаадын агаарын тээвэрлэгчидтэй хамтран ажиллана.

9.1.1.2 Агаарын тээвэрлэгчдээс нислэгийн хүсэлтийг “Нислэгийн төлөвлөлт, гүйцэтгэл бүртгэлийн ATFMS систем”-ийн онлайн модуль болон fpd@mcaa.gov.mn цахим хаягаар дамжуулан авна.

9.1.1.3 Агаарын тээвэрлэгч байгууллагуудтай холбоо барих утасны дугаар, цахим хаяг, шуудангийн хаягийн бүртгэлийг тогтмол хийж шинэчлэх; .

9.1.1.4 Агаарын тээвэрлэгч байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн, Монгол Улсын агаарын зайд үйлдэгдэх нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийг сайжруулах чиглэлээр идэвх санаачилгатай ажиллах;.

9.1.1.5 Албаны хэмжээнд мөрдөгдөж буй дүрэм, журам, зааврыг шинээр болон шинэчлэн батлагдах баримт бичгийн боловсруулалтад санал өгч ажиллана.

9.1.1.6 Ажилтны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг тогтоосон хугацаанд нь тайлагнана.

9.1.1.7 Хэсгийн ажилчид байгууллагын үйл ажиллагаатай холбогдолтой хууль, дүрэм, журам, заавар, хөдөлмөрийн дотоод журмыг мөрдлөг болгон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн шаардлага, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж ажиллана.

9.1.1.8 Хэсгийн ажилчид эрүүл мэндийн шалтгаан, зайлшгүй шаардлагаар чөлөө авахад “ИНҮТ” ТӨХХК - ийн “Хөдөлмөрийн дотоод журам” -ыг баримтлан чөлөө авах өдрийн өмнөх ажлын өдөр хэсгийн даргад мэдэгдэнэ.

9.1.1.9 Хэсгийн ажилчид нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үйл ажиллагаанд гарч буй дутагдал, нислэгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөх аливаа аюул, эрсдэл, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаатай холбоотой санал хүсэлт, үл нийцлийн талаарх мэдээллийг удирдлагад цаг алдалгүй мэдээлнэ.

9.1.1.10 Бүх нийтийн, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Гамшгаас хамгаалах тухай Монгол Улсын хуулийн хүрээнд удирдах дээд байгууллагын тогтоосон ажлын горимыг мөрдөн ажиллана.

ИНҮТ-АБЧҮГ №02
ХЯНАЛТТАЙ

9.1.1.11 Хэсгийн ажилчид албаны удирдлагын шийдвэрээр бусад ажлын байранд шилжин ажиллана.

9.1.2 НЦХЗХ-ийн бүтэц.




9.1.3 НИСЛЭГИЙН УРСГАЛ ТӨЛӨВЛӨЛТИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ГҮЙЦЭТГЭХ ЧИГ ҮҮРЭГ:

9.1.3.1 Хэсгийн даргаас өгөгдсөн үүрэг даалгаврыг биелүүлж, ажил үүргийн хуваарилалтыг мөрдлөг болгон ажиллана.

9.1.3.2 ИНЕГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газраас ирүүлсэн агаарын навигацийн хураамжийн авлага хуримтлагдсан мэдэгдлийг хүлээн авч холбогдох агаарын тээвэрлэгчдэд төлбөр төлөгдөөгүй талаарх мэдээллийг цахим хаягаар хүргүүлнэ.

9.1.3.3 ИНЕГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газраас ирүүлсэн агаарын навигацийн хураамжийн авлага урт хугацаанд хуримтлагдсан талаарх албан бичгийг үндэслэн хуваарьт нислэг үйлдэж буй агаарын тээвэрлэгчид олгосон нислэгийн зөвшөөрлийн дугаарыг түр түдгэлзүүлж болох ба авлагыг барагдуулсан талаарх албан бичгийг үндэслэн тухайн агаарын тээвэрлэгчийн түр түдгэлзүүлсэн нислэгийн төлөвлөлтийг сэргээнэ.

9.1.3.4 Нислэгийн зөвшөөрлийн дугаарыг баталгаажуулалт хийж батлагдсан загварын дагуу нислэгийг төлөвлөнө.

НҮҮТ-АБЧҮГ №02
ХЯНАЛТТАЙ

9.1.3.5 Агаарын тээвэрлэгч байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн, Монгол Улсын агаарын зайд үйлдэгдэх нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийг нэмэгдүүлэх чиглэлээр идэвх санаачилгатай ажиллана.

9.1.3.6 Нислэгийн төрлөөс хамаарч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

**а) Олон улсын хуваарьт өнгөрөлтийн нислэг**

i. Олон улсын хуваарьт өнгөрөлтийн нислэгийн хүсэлтийг гадаадын агаарын тээвэрлэгчээс НХТЗОЖ-ын 4.2.1-д заасан хугацааг баримтлан Хавсралт 2 маягтын дагуу хүлээн авч "Нислэгийн төлөвлөлт гүйцэтгэл бүртгэлийн ATFMS систем"-д оруулан төлөвлөлтийн мэдээллийн сан үүсгэнэ.

ii. Олон улсын хуваарьт өнгөрөлтийн нислэгт урт хугацааны төлөвлөлт хийж, удирдлагад танилцуулан, нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үе шатуудад төлөвлөнө

iii. Олон улсын өнгөрөлтийн нислэгийн төлөвлөлтөд нэг удаагийн нислэг нэмэх тохиолдолд хүсэлтийг агаарын тээвэрлэгчээс НХТЗОЖ-ын 5.2.1-т заасан хугацааг баримтлан Хавсралт 2 маягт эсхүл түүнд багтсан мэдээллийн дагуу хүлээн авч, удирдлагад танилцуулан, нислэгийг хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үе шатуудад төлөвлөлтөд тусгана.

iv. Олон улсын өнгөрөлтийн нислэгийн төлөвлөлтөд 2 буюу түүнээс дээш нислэгийн өөрчлөлт, нэмэгдэл нислэгийн хүсэлтийг агаарын тээвэрлэгчээс НХТЗОЖ-ын 5.2.2-т заасан хугацааг баримтлан Хавсралт 2 маягт эсхүл түүнд багтсан мэдээллийн дагуу хүлээн авч, удирдлагад танилцуулан, нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үе шатуудад төлөвлөнө.

v. Олон улсын хуваарьт өнгөрөлтийн нислэгийн нэмэгдэл, цуцалсан, өөрчлөлт орсон нислэгийн зөвшөөрлийн дугаарын баталгаажуулалтыг хүсэлтийн хамт ШТХ-ийн tpu@ncac.mn цахим хаягаар хүргүүлнэ.

vi. Олон улсын хуваарьт өнгөрөлтийн нислэг шинээр үйлдэх агаарын тээвэрлэгчийн нислэгийн хүсэлтийг хүлээн авч түүнд холбогдох баримт бичгийн бүрдэлтийг бүрдүүлэн удирдлагад танилцуулан, нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үе шатуудад төлөвлөнө.

vii. Нислэгийн зөвшөөрлийн дугаарыг баталгаажуулалт хийхдээ батлагдсан маягтын дагуу нислэгийг төлөвлөнө.

viii. Монгол Улсын агаарын зайд үйлдэгдэх олон улсын хуваарьт өнгөрөлтийн нислэгийн урт хугацааны /өвөл, зуны улирал/ төлөвлөлтийн судалгааг удирдлагад танилцуулан санал авна.

xi. Олон улсын хуваарьт өнгөрөлтийн нислэгийн зөвшөөрөл, нэмэгдэл, өөрчлөлт болон цуцалсан мэдээний бүртгэлийг хийнэ.

**б) Олон улсын хуваарьт хөөрөлт, буултын нислэг**

ХЯНАЛТТАЙ

i. Чингис хаан" ОУНБ-д хөөрөлт, буулт үйлдэх олон улсын хуваарьт нислэгийн хүсэлтийг агаарын тээвэрлэгчээс НХТЗОЖ-ын 4.2.1-д заасан хугацааг баримтлан Хавсралт 2 маягтын дагуу хүлээн авч "Нислэгийн төлөвлөлт гүйцэтгэл бүртгэлийн ATFMS систем"д оруулна төлөвлөлтийн мэдээллийн сан үүсгэнэ.

ii. Монгол Улсын агаарын зайд үйлдэгдэх олон улсын хуваарьт хөөрөлт, буултын нислэгийн /өвөл, зуны улирал/-ын хүсэлтийг ЦХЗ-өөс батлагдсан хуваарийн дагуу удирдлагад танилцуулан, нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үе шатуудад төлөвлөнө.

iii. Монгол Улсын агаарын зайд үйлдэгдэх Олон улсын хуваарьт хөөрөлт буултын нислэгийн урт хугацааны "өвөл, зуны улирал"-ын төлөвлөлтийн судалгааг өвөл, зуны улирал тутам гаргаж удирдлагад танилцуулан санал авна.

iv. Батлагдсан хуваарьт олон улсын хөөрөлт, буултын нислэгийн төлөвлөлтөд нэг удаагийн нислэг нэмэх тохиолдолд хүсэлтийг агаарын тээвэрлэгчээс НХТЗОЖ-ын 5.2.1-т заасан хугацааг баримтлан Хавсралт 2 маягт эсхүл түүнд багтсан мэдээллийн дагуу хүлээн авч, удирдлагад танилцуулан нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үе шатуудад төлөвлөлтөд тусгана.

v. Батлагдсан хуваарьт олон улсын хөөрөлт, буултын нислэгийн төлөвлөлтөд 2 буюу түүнээс дээш нислэгийн өөрчлөлт, нэмэгдэл нислэгийн хүсэлтийг агаарын тээвэрлэгчээс НХТЗОЖ-ын 5.2.2-т заасан хугацааг баримтлан Хавсралт 2 маягт эсхүл түүнд багтсан мэдээллийн дагуу хүлээн авч, удирдлагад танилцуулан, нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үе шатуудад төлөвлөнө.

vi. Батлагдсан олон улсын хуваарьт хөөрөлт, буултын нислэгт 2-4 удаагийн нэмэгдэл болон өөрчлөлт орсон тохиолдолд нислэгийн мэдээллийг ЧХОУНБ-ын Шуурхай удирдлага, хяналтын төвийн airportops@nubia-llc.mn цахим шуудангийн хаягаар тухай бүрд нь дамжуулж "Нью Улаанбаатар Интернэйшнл эйрпорт" ХХК болон агаарын тээвэрлэгчидтэй хамтран агаарын хөлгийн зогсоолын мэдээллийн хариу баталгаажуулалтыг авч хамтарч ажиллана.

vii. Олон улсын хөөрөлт буултын нислэгийн батлагдсан цагийн хуваарьт ЦХЗ-өөс оруулсан өөрчлөлтийн дагуу нислэгийг хэсгийн даргад танилцуулан нислэгийн хүсэлтийг баталгаажуулан нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үе шатуудад төлөвлөнө.

viii. Олон улсын хуваарьт нислэгийн нэмэгдэл, цуцалсан, өөрчлөлт орсон нислэгийн зөвшөөрлийн дугаарын баталгаажуулалтыг хүсэлтийн хамт ШТХ-ийн tpu@mcaa.gov.mn цахим хаягаар хүргүүлнэ.

ix. Олон улсын хуваарьт хөөрөлт, буултын нислэг шинээр үйлдэхэд нислэгийн хүсэлтийг хүлээн авч түүнд холбогдох баримт бичгийн бүрдэлтийг хийн, зааврын Хавсралт 5-ын дагуу удирдлагад танилцуулан, нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үе шатуудад төлөвлөнө.

МНУТ-АБЧУГ №03
ХЯНАЛТТАЙ

Нислэгийн зөвшөөрлийн дугаарыг баталгаажуулалт хийхдээ батлагдсан загварын дагуу нислэгийг төлөвлөнө.

### в) Олон улсын хуваарьт бус нислэг




ИНУТ-ААС ИЛГЭЭ
ХЯНАЛТТАЙ

i. Олон улсын хуваарьт бус өнгөрөлт, хөөрөлт буултын нислэгийн хүсэлтийг агаарын тээвэрлэгчээс НХТЗОЖ-ын 4.3.2-т заасан хугацааг баримтлан, Хавсралт 3 маягт болон түүнд багтсан мэдээллийн дагуу хүлээн авч, хэсгийн даргад танилцуулан, нислэгийн зөвшөөрлийн дугаарыг баталгаажуулан нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үе шатуудад нислэгийг төлөвлөлтөд тусгана.

ii. Нислэгийн зөвшөөрлийн дугаарыг баталгаажуулахдаа батлагдсан загварын дагуу нислэгийг төлөвлөнө.

iii. Монгол улсад арилжааны зорилгоор агаарын тээврийн үйл ажиллагаа явуулах гадаадын агаарын тээвэрлэгчээс ирүүлсэн хуваарьт бус олон улсын хөөрөлт, буултын нислэгийн зөвшөөрлийн дугаарыг олгохдоо ИНД-129.1 дүрмийн шаардлагыг баримтална.

iv. Дотоодын агаарын тээвэрлэгчийн олон улсын хуваарьт бус хөөрөлт, буултын нислэгийн хүсэлтийг НХТЗОЖ-ын 4.3.2-ын хугацааг баримтлан Хавсралт 3 маягт эсхүл түүнд багтсан мэдээллийг хүлээн авч, зааврын Хавсралт 4-ийн дагуу удирдлагад танилцуулан, нислэгийн зөвшөөрлийн дугаарыг баталгаажуулан, нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үе шатуудад төлөвлөнө.

v. Олон нийтийг хамарсан аюулт цар тахал, өвчин, байгалийн гамшиг гэх мэт онцгой нөхцөл үүссэн тохиолдолд хуваарьт бус олон улсын хөөрөлт, буултын нислэгийн мэдээллийг PDF файлаар өдөр бүр 17.00 цагаас өмнө албаны даргын зөвлөлд fpd_office@ncac.mn, ШТХ-т tpu@mcaa.gov.mn, болон харилцан ажиллагааны зохицуулалтын журмын дагуу холбогдох алба, салбар, нэгж, байгууллагуудад хүргүүлнэ.

vi. Гадаадын агаарын тээвэрлэгчээс "Чингис хаан" ОУНБ, "Буянт-Ухаа" ОУНБ-д хөөрөлт, буулт үйлдэх хуваарьт бус нислэгийн хүсэлтийг НХТЗОЖ-ын 4.3.2-т заасан хугацааг баримтлан 8.2.1-д заасан баримт бичгийн бүрдүүлж, Хавсралт 3 эсхүл түүнд багтсан мэдээллийг хүлээн авч зааврын Хавсралт 3-ын дагуу удирдлагад танилцуулан, нислэгийн хөдөлгөөний урсгал төлөвлөлтийн менежментийн үе шатуудад төлөвлөнө.

vii. Олон улсын хуваарьт бус өнгөрөлтийн нислэгийн хүсэлтийн хувийг ИНЕГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт fed.charter@mcaa.gov.mn цахим хаягаар хүргүүлнэ.

viii. "Чингис хаан" ОУНБ-д үйлдэгдэх олон улсын хуваарьт бус хөөрөлт, буултын нислэгийн хүсэлтийн хувийг ИНЕГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт fed.charter@mcaa.gov.mn цахим хаягаар, "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн Нисэх буудлын маркетингийн хэлтэст marketing@nubia-llc.mn цахим хаягаар хүргүүлнэ.

ix. Олон улсын хуваарьт бус өнгөрөлт, хөөрөлт буултын нислэгийн хүсэлтийг НХТЗОЖ-ын 4.3.1, 4.3.2-т заасан хугацаанаас богино буюу 4.3.3, 4.3.4-т заасан хугацааг баримтлан Хавсралт 3 маягт болон түүнд багтсан мэдээллийн дагуу
